



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН



Улаанбаатар хот
2020 он

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
2020 ОНЫ ЭХНИЙ 9 САРЫН
УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ГАРЧИГ

ОРШИЛ.....	3
НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААРХ ДНБ	5
ДНБ, оны үнээр.....	5
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	6
Улирлын нөлөөллийг арилгасан ДНБ	6
Эдийн засагт голлох салбаруудын үйлдвэрлэл.....	7
ХОЁР. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ	11
ДНБ, оны үнээр.....	12
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	13
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр.....	5
Хүснэгт 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	6
Хүснэгт 3. ДНБ-ий өсөлт, бууралтад салбаруудын оролцоо, пунктээр	7
Хүснэгт 4. Хураасан ургац, жил бүрийн 10-р сарын 1-ний байдлаар.....	7
Хүснэгт 5. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт, экспорт	8
Хүснэгт 6. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, оны үнээр.....	12
Хүснэгт 7. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр	13
Хүснэгт 8. ДНБ-ий бодит өсөлт, бууралтад бүрэлдэхүүн хэсгийн оролцоо, пунктээр	13
Хүснэгт 9. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд	15
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Зураг 1. Салбаруудын 2020 оны эхний 9 сарын нэмэгдэл өртгийн өсөлт, бууралт, хувиар	5
Зураг 2. ДНБ-ий салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар	5
Зураг 3. ДНБ-ий өсөлт, бууралт, уул уурхай, уул уурхайн бус салбараар, хувиар	6
Зураг 4. ДНБ (улирлын нөлөөллийг арилгасан)-ий цэвэр өсөлт, бууралт хувиар (2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх улирлаас).....	6
Зураг 5. Бойжуулсан төл, том малын зүй бус хорогдол,.....	7
мянган толгой	7
Зураг 6. Боловсруулах салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар	8
Зураг 7. Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр, тэрбум төгрөг	9
Зураг 8. Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, импорт	9
Зураг 9. Дотоод худалдааны борлуулалт, барааны импортын хэмжээ	9
Зураг 10. Тээврийн нийт орлого, тэрбум төгрөг	10
Зураг 11. Зочид буудал, нийтийн хоолны салбарын орлого, оны үнээр, тэрбум төгрөг	10
Зураг 12. Зээлийн өр, хадгаламжийн үлдэгдэл, их наяд төгрөг, жил бүрийн 9 дүгээр сарын эцэст	10
Зураг 13. Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин хөлсний хэмжээ, тэрбум төгрөг.....	11
Зураг 14. Бүтээгдэхүүний татвар, төрлөөр, дүнд эзлэх хувиар	11
Зураг 15. ДНБ-ий 2020 оны эхний 9 сарын бууралт, оны болон 2010 оны зэрэгцүүлэх үнээр, хувиар ..	11
Зураг 16. Экспортын топ-5 бүтээгдэхүүн	14
Зураг 17. Импортын топ-5 бүтээгдэхүүн	14

Тайлбар

* Урьдчилсан гүйцэтгэл

¹Нөөц ашиглалтын хүснэгтийн үр дүнгээр тодотгосон

²ААНБ-ийн жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо

ОРШИЛ

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тайлант хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцно. Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж, нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспорт (экспорт, импортын зөрүү)-ын нийлбэрээр тооцохыг эцсийн ашиглалтын; ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар (үйлдвэрлэл, импортын татвар, татаасын зөрүү), үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ.

ДНБ-ийг улирлаар үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар тооцно. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ нь шинээр бий болсон нэмэгдэл өртөг аль салбарт бий болсныг харуулах бол эцсийн ашиглалтын аргаарх ДНБ нь үйлдвэрлэгчдийн бий болгосон нэмэгдэл өртгийг зах зээлийн арилжаа солилцооны эцэст хаана, ямар хэлбэрийн өртөг болгож ашигласныг харуулна. Энэ нь өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал, бараа үйлчилгээний цэвэр экспорт гэсэн дэд хэсгүүдэд хуваарилагдана.

Мөн эдийн засгийн бодит өсөлтийг үнийн өсөлтийн нөлөөллийг арилгасан буюу зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий өөрчлөлтөөр тодорхойлно.

Уг танилцуулгад ДНБ-ий үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын аргаар тооцсон үр дүнг болон ДНБ-тэй холбогдох макро-эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүдийг тусгасан.



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (ДНБ)

ᠳᠣᠲᠤᠨᠨᠢᠶᠢᠨᠪᠦᠲᠡᠭᠦᠳᠡᠬᠦᠭᠦᠨ

Монгол Улсын
эдийн засаг 2020 оны
эхний 9 сард



Өсөлт, бууралт
Оролцоо, пунктээр

ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ-ИЙ БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР




* - Уул уурхай, олборлолтын салбар ороогүй

Эдийн засаг 2020 оны эхний 9 сард 7.3 хувиар буурлаа.

НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААРХ ДНБ

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ, 2020 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс оны үнээр 3.5 хувь, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 7.3 хувиар тус тус буурлаа (Зураг 1).

Зураг 1. Салбаруудын 2020 оны эхний 9 сарын нэмэгдэл өртгийн өсөлт, бууралт, хувиар



ДНБ, оны үнээр


ДНБ, оны үнээр 2020 оны эхний 9 сард 26.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 953.5 (3.5%) тэрбум төгрөгөөр буурлаа. ДНБ-ий бууралтад уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг өмнөх оны мөн үеэс 1.2 (19.3%) их наяд төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр

	2017 ¹	2018 ¹	2019 ²	2020*	2019 ² I-IX	2020* I-IX
	I-IX	I-IX	I-IX	I-IX	2018 ¹ I-IX	2019 ² I-IX
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	20 370.4	23 881.7	27 399.7	26 446.2	114.7	96.5
Хөдөө аж ахуй	2 397.3	2 932.1	3 084.1	3 554.5	105.2	115.3
Уул уурхай, олборлолт	4 686.1	5 545.5	6 447.2	5 203.9	116.3	80.7
Аж үйлдвэр, барилга	2 614.8	3 148.1	3 494.3	3 498.8	111.0	100.1
Үйлчилгээ	8 661.3	9 470.1	11 153.7	11 269.7	117.8	101.0
Бүтээгдэхүүний цэвэр татвар	2 010.8	2 785.8	3 220.4	2 919.3	115.6	90.7

ДНБ-ий салбарын бүтцийг авч үзвэл, 2020 оны эхний 9 сард үйлчилгээ 42.6 хувь, уул уурхай, олборлолт 19.7 хувь, хөдөө аж ахуй 13.4 хувь, аж үйлдвэр, барилга 13.2 хувийг тус тус эзэлж байна (Зураг 2).

Зураг 2. ДНБ-ий салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар



ДНБ-ий 2020 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр салбарын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хөдөө аж ахуйн салбарынх 2.2 пунктээр, аж үйлдвэр, барилгын салбарынх 0.5 пунктээр, үйлчилгээний салбарынх 1.9 пунктээр тус тус нэмэгдэж, уул уурхай, олборлолтын салбарынх 3.9 пунктээр, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.7 пунктээр буурсан байна.

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр


ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2020 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 12.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.0 (7.3%) их наяд төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 595.5 (20.7%) тэрбум төгрөгөөр, бүтээгдэхүүний цэвэр татвар 146.6 (8.4%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 401.4 (7.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

	2017 ¹	2018 ¹	2019 ²	2020*	2019 ²	2020*
	I-IX	I-IX	I-IX	I-IX	2018 ¹	2019 ²
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	12 062.5	12 849.9	13 735.9	12 735.6	106.9	92.7
Хөдөө аж ахуй	1 818.6	1 857.0	1 935.5	2 154.9	104.2	111.3
Уул уурхай, олборлолт	2 651.3	2 692.0	2 880.9	2 285.4	107.0	79.3
Аж үйлдвэр, барилга	1 261.3	1 355.5	1 457.9	1 381.8	107.6	94.8
Үйлчилгээ	4 997.5	5 305.5	5 715.8	5 314.4	107.7	93.0
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1 333.8	1 640.0	1 745.8	1 599.2	106.5	91.6

Зураг 3. ДНБ-ий өсөлт, бууралт, уул уурхай, уул уурхайн бус салбараар, хувиар

Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 2019 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар өсөхөд нийт эдийн засаг 6.9 хувиар өсөж байсан бол 2020 оны эхний 9 сард уул уурхай, олборлолтын салбарын үйл ажиллагаа 20.7 хувиар буурснаар нийт эдийн засаг 7.3 хувиар агшсан байна (Зураг 3).




Уул уурхайн бус салбар 2020 оны эхний 9 сард нийт дүнгээрээ **бууралттай** гарсан байна.

Улирлын нөлөөллийг арилгасан ДНБ

Улирлын нөлөөллийг арилган тооцсон ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2020 оны 3-р улиралд өмнөх улирлаас 4.4 хувиар өсөв (Зураг 4).

Зураг 4. ДНБ (улирлын нөлөөллийг арилгасан)-ий цэвэр өсөлт, бууралт хувиар (2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх улирлаас)



Эдийн засагт голлох салбаруудын үйлдвэрлэл

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард 7.3 хувиар буурсны (-4.3) пункт нь уул уурхай, олборлолтын салбар, (-1.5) пункт нь тээвэр, мэдээлэл холбооны салбар, (-1.5) пункт нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар, (-1.1) пункт нь бүтээгдэхүүний цэвэр татварт тус тус ногдож байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ДНБ-ий өсөлт, бууралтад салбаруудын оролцоо, пунктээр

	2018 ¹				2019 ²				2020*		
	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX
ДНБ-ий өсөлт, %	6.2	6.5	6.5	7.2	8.8	7.8	6.9	5.2	-10.7	-9.7	-7.3
Хөдөө аж ахуй	0.2	0.2	0.3	0.6	0.1	0.7	0.6	1.1	0.5	1.9	1.6
Уул уурхай, олборлолт	0.9	0.5	0.3	1.3	3.6	2.6	1.5	-0.1	-7.7	-6.2	-4.3
Аж үйлдвэр, барилга	1.0	1.0	0.8	1.3	0.6	0.6	0.8	1.1	0.6	-0.4	-0.6
Боловсруулах	0.4	0.7	0.6	1.0	0.4	0.4	0.6	0.8	0.2	-0.3	-0.4
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.3	0.2	0.2	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.2	0.1	0.0
Барилга	0.3	0.1	0.1	0.2	0.1	0.1	0.2	0.3	0.1	-0.2	-0.2
Үйлчилгээ	2.2	2.2	2.6	2.0	3.9	3.2	3.2	2.4	-3.1	-3.4	-2.9
Бөөний, жижиглэн худалдаа	0.7	0.8	0.6	0.3	1.7	1.4	1.2	0.9	-1.2	-1.5	-1.5
Тээвэр, мэдээлэл, холбоо	0.2	0.4	0.9	0.8	0.5	0.3	0.7	0.3	-2.1	-1.8	-1.5
Үйлчилгээний бусад	1.3	1.0	1.1	1.0	1.7	1.4	1.3	1.2	0.2	-0.1	0.1
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1.9	2.6	2.5	2.0	0.7	0.6	0.8	0.6	-1.0	-1.6	-1.1


Хөдөө аж ахуйн салбар

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өссөн байна. ДНБ-ий 7.3 хувийн бууралтад 1.6 пунктээр эерэгээр нөлөөлжээ.

Зураг 5. Бойжуулсан төл, том малын зүй бус хорогдол, мянган толгой

Улсын хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 31.0 сая хээлтэгч малын 23.9 сая (77.0%) нь 2020 оны эхний 9 сард төллөсөн байна. Гарсан төлийн 95.7 хувь буюу 22.9 сая төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеэс 128.5 мянгаар буурсан байна.

Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний 9 сард улсын хэмжээнд 1.3 сая болж, өмнөх оны мөн үеэс 0.6 (78.4%) саяар нэмэгджээ (Зураг 5).



Улсын хэмжээнд 2020 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар үр тариа 132.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 8.1 (6.5%) мянган тонноор, төмс 67.4 (48.7%) мянган тонноор, хүнсний ногоо 19.0 (32.0%) мянган тонноор нэмэгдэж, бэлтгэсэн хадлан 274.8 (35.2%) мянган тонноор буурлаа (хүснэгт 4).

Хүснэгт 4. Хураасан ургац, жил бүрийн 10-р сарын 1-ний байдлаар

	2017	2018	2019	2020	<u>2019</u> 2018	<u>2020</u> 2019
	ТОНН				ХУВЬ	
Үр тариа	166 116.2	141 518.4	124 385.4	132 460.5	87.9	106.5
Төмс	87 298.4	150 412.7	138 478.8	205 904.0	92.1	148.7
Хүнсний ногоо	63 136.5	73 393.4	59 429.4	78 474.0	81.0	132.0
Бэлтгэсэн хадлан	646 550.3	634 710.6	781 328.1	506 529.4	123.1	64.8

Уул уурхай, олборлолтын салбар

Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 20.7 хувиар буурсан бөгөөд ДНБ-ий 7.3 хувийн бууралтын (-4.3) пункт нь уг салбарт ногдож байна.

Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 9 сард 7.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.1 (21.5%) их наяд төгрөгөөр буурсан байна.

Уул уурхайн гол нэр төрлийн 8 бүтээгдэхүүнээс 4 бүтээгдэхүүний олборлолт өмнөх оны мөн үеэс (газрын тос 52.3 хувиар, нүүрс 40.7 хувиар, цайрын хүдэр, баяжмал 11.5 хувиар, зэсийн баяжмал 2.5 хувиар) буурсан. Мөн уул уурхайн 4 бүтээгдэхүүний экспорт 1.9-50.9 хувиар тус тус буурчээ (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт, экспорт

Уул уурхайн бүтээгдэхүүн	2018 I-IX		2019 I-IX		2020* I-IX		2020* I-IX 2019 I-IX	
	Олборлолт	Экспорт	Олборлолт	Экспорт	Олборлолт	Экспорт	Олборлолт	Экспорт
	мянган тонн						хувь	
Нүүрс	33 764.8	27 380.3	38 583.7	28 743.8	22 884.8	19 868.0	59.3	69.1
Газрын тос, мянган барель	5 009.6	4 811.7	5 125.0	4 842.0	2 445.7	2 379.7	47.7	49.1
Молибдений баяжмал, тонн	4 033.4	4 428.6	3 823.9	4 229.4	4 220.1	4 600.2	110.4	108.8
Алт, кг	14 532.4	3 431.9	11 017.5	7 464.5	14 880.3	20 247.0	135.1	271.2
Төмрийн хүдэр, баяжмал	7 167.7	5 314.7	8 845.7	6 134.3	10 386.8	6 252.5	117.4	101.9
Зэсийн баяжмал	975.1	1 073.0	964.7	1 066.3	940.7	1 020.7	97.5	95.7
Хайлуур жонш, баяжмал	147.3	344.7	130.8	500.0	157.1	490.7	120.1	98.1
Цайрын хүдэр, баяжмал	62.6	92.2	62.5	100.7	55.3	102.7	88.5	102.0

Аж үйлдвэр, барилга

Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар буурсан байна. Энэхүү бууралтад боловсруулах үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг 6.6 хувь, барилгын салбарынх 6.3 хувиар буурсан нь нөлөөлжээ.

Боловсруулах салбар

Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 9 сард 2.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 225.0 (8.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Хүнс, ундаа үйлдвэрлэл 2020 оны эхний 9 сард 1175.0 тэрбум төгрөг болж, боловсруулах салбарын нийт үйлдвэрлэлийн 46.8 хувийг эзэлж байна (Зураг 6).

Зураг 6. Боловсруулах салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар



Цахилгаан эрчим хүч болон усан хангамжийн салбар

Цахилгаан эрчим хүч болон усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 9 сард 909.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 63.5 (7.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Цахилгаан эрчим хүчний нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар, усан хангамжийн салбарынх 1.8 хувиар өссөн байна (Зураг 7).

Зураг 7. Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр, тэрбум төгрөг




Барилгын салбар

Барилга угсралт, их засварын ажил 2020 оны эхний 9 сард оны үнээр 3.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 54.9 (1.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Барилгын үндсэн материал болох төмөр, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэлийн дотоодын үйлдвэрлэл 1.0 хувиар, чулуу, гипс, цемент, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 0.5 хувиар буурчээ (Зураг 8).

Зураг 8. Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, импорт



Үйлчилгээний салбар

Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар буурсан байна. ДНБ-ий 7.3 хувийн бууралтын (-1.5) пункт нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, (-1.5) пункт нь тээвэр, мэдээлэл, холбооны салбарт ногдож байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбар

Бөөний болон жижиглэн худалдаа (дотоод худалдаа)-ны нийт борлуулалт 2020 оны эхний 9 сард 15.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (9.8%) их наяд төгрөгөөр буурлаа.

Импортын хэмжээ 2020 оны эхний 9 сард 3.9 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 0.7 (14.6%) тэрбум америк доллароор буурсан байна (Зураг 9).

Зураг 9. Дотоод худалдааны борлуулалт, барааны импортын хэмжээ



Тээвэр, мэдээлэл, холбооны салбар


Тээврийн салбарын нийт орлого 2020 оны эхний 9 сард 1.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 459.7 (30.5%) тэрбум төгрөгөөр бүүрчээ (Зураг 10). Мэдээлэл, холбооны салбарын нийт орлого 2020 оны эхний 9 сард 995.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 59.3 (6.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 10. Тээврийн нийт орлого, тэрбум төгрөг

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2020 оны эхний 9 сард 39.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10.9 (21.4%) сая тонноор буурсан байна.

Энэхүү бүүралтад авто тээврээр тээсэн ачаа 12.6 (41.3%) сая тонн, агаарын тээврээр тээсэн ачаа 2.3 (54.8%) мянган тонноор буурсан нь голлон нөлөөлжээ.


Төмөр замаар тээсэн ачаа 2020 оны эхний 9 сард 22.1 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (8.1%) сая тонноор өсжээ.



Зочид буудал, нийтийн хоолны үйл ажиллагаа

Зочид буудлын салбарын нийт орлого 2020 оны эхний 9 сард 101.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 105.9 (51.0%) тэрбум төгрөгөөр, нийтийн хоолны салбарын орлого 328.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 28.8 (8.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна (Зураг 11).

Зураг 11. Зочид буудал, нийтийн хоолны салбарын орлого, оны үнээр, тэрбум төгрөг



Санхүү, даатгалын салбар

ААНБ, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 9 дүгээр сарын эцэст 17.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.8 (4.4%) их наяд төгрөгөөр бүүрч, нийт хадгаламжийн хэмжээ 16.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.0 (21.6%) их наяд төгрөгөөр өсжээ (Зураг 12).

Зураг 12. Зээлийн өр, хадгаламжийн үлдэгдэл, их наяд төгрөг, жил бүрийн 9 дүгээр сарын эцэст




Төрийн удирдлага, батлан хамгаалах салбар, бусад төсөвт байгууллага

Үйлчилгээний бусад салбарт орсон мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа; төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа; боловсрол; нийгмийн халамж; урлаг, үзвэр, тоглоом наадам зэрэг салбарын нэмэгдэл өртгийн дийлэнх хувь нь төсөвт байгууллага байдаг.

Зураг 13. Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин хөлсний хэмжээ, тэрбум төгрөг

Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин хөлс 2020 оны эхний 9 сард 2.1 их наяд төгрөг хүрч, өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар нэмэгдсэн байна (Зураг 13).




Бүтээгдэхүүний татвар, татаас

Бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард 1.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар буурчээ.

Нэмэгдсэн өртгийн албан татвар 2020 оны эхний 9 сард оны үнээр өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар, онцгой албан татвар 11.4 хувиар, гадаад худалдааны татвар 5.7 хувиар буурч, тусгай зориулалтын орлого 2.4 хувиар өсжээ.

Зураг 14. Бүтээгдэхүүний татвар, төрлөөр, дүнд эзлэх хувиар

Бүтээгдэхүүний татварын бүтцийн хувьд 2020 оны эхний 9 сард гадаад худалдааны татварын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр, нэмэгдсэн өртгийн албан татварынх 0.1 пунктээр нэмэгдэж, харин онцгой албан татварынх 0.7 пунктээр буурсан бол тусгай зориулалтын орлогын өмнөх оны түвшинд байлаа (Зураг 14).



ХОЁР. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ


Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, 2020 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буурлаа.

Зураг 15. ДНБ-ий 2020 оны эхний 9 сарын бууралт, оны болон 2010 оны зэрэгцүүлэх үнээр, бүрэлдэхүүн хэсгээр, хувиар

Эцсийн хэрэглээ, оны үнээр 2020 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 7.1 хувиар өссөн.

Экспорт, оны үнээр 14.4 хувиар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 7.9 хувиар, импорт, оны үнээр 19.0 хувиар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 8.0 хувиар буурсан байна.

Хөрөнгийн нийт хуримтлал, оны үнээр 29.6 хувиар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 33.6 хувиар буурчээ (Зураг 15).



ДНБ, оны үнээр

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2020 оны эхний 9 сард 26.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 372.7 (1.4%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 6. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, оны үнээр

Бүрэлдэхүүн	2017	2018	2019 ¹	2020*	<u>2019¹ I-IX</u>	<u>2020* I-IX</u>
	I-IX	I-IX	I-IX	I-IX	2018 I-IX	2019 ¹ I-IX
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	20 156.7	23 341.5	27 179.7	26 807.0	116.4	98.6
Эцсийн хэрэглээ	13 531.9	15 463.6	18 132.1	19 714.5	117.3	108.7
Өрхийн аж ахуй, ӨҮАББ-ын хэрэглээ ²	11 088.1	12 899.8	15 015.8	16 099.7	116.4	107.2
Төрийн байгууллагын хэрэглээ	2 443.9	2 563.8	3 116.3	3 614.9	121.6	116.0
Хөрөнгийн нийт хуримтлал	5 657.1	8 719.3	9 884.2	6 963.3	113.4	70.4
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	4 355.7	6 584.5	8 217.4	8 045.1	124.8	97.9
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ³	1 301.4	2 134.8	1 666.8	-1 081.8	78.1	-
Бараа, үйлчилгээний цэвэр экспорт	967.7	- 841.4	- 836.5	129.2	-	-
Бараа, үйлчилгээний экспорт	12 437.5	14 222.9	17 441.3	14 927.9	122.6	85.6
Бараа, үйлчилгээний импорт (-)	11 469.8	15 064.3	18 277.8	14 798.8	121.3	81.0

Тайлбар: ^А - Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

^Б - Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлалыг оруулсан.

Эцсийн хэрэглээ, оны үнээр 2020 оны эхний 9 сард 19.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (8.7%) их наяд төгрөгөөр өссөн байна. Эцсийн хэрэглээний 81.1 хувийг өрхийн аж ахуй болон ӨҮАББ-ын хэрэглээ бүрдүүлж байна. Өрхийн хэрэглээний 41.7 хувийг хүнсний хэрэглээ, 21.4 хувийг хүнсний бус хэрэглээ, 36.9 хувийг үйлчилгээ эзэлж байна. Өрхийн хүнсний хэрэглээ өмнөх оны мөн үеэс 869.1 (15.0%) тэрбум төгрөг, үйлчилгээ 227.6 (4.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны мөн үеэс өрхийн хүнсний хэрэглээ өсөхөд мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ 18.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ 20.5 хувь, цэвэр ус, ундаа, шүүсний хэрэглээ 44.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн. Өрхийн хүнсний бус хэрэглээний өсөлтөд тээврийн хэрэгсэл, засварын үйлчилгээ 16.3 хувь, эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ 17.2 хувь, холбооны үйлчилгээ 15.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгийн нийт хуримтлал, оны үнээр 2020 оны эхний 9 сард 7.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.9 (29.6%) их наяд төгрөгөөр буурсан байна. Хөрөнгийн нийт хуримтлалын 115.5 хувийг үндсэн хөрөнгийн нийт хуримтлал бүрдүүлж байна.

Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал өмнөх оны мөн үеэс 172.2 (2.1%) тэрбум төгрөгөөр өсөж, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт 2.7 (164.9%) их наяд төгрөгөөр буурлаа.

Үндсэн хөрөнгийн хуримтлалын биологийн өсөж үрждэг хөрөнгө 202.4 (22.6%) тэрбум төгрөгөөр өсөж, машин тоног, төхөөрөмж 267.3 (7.8%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Бараа, үйлчилгээний экспорт, оны үнээр 2020 оны эхний 9 сард 14.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (14.7%) их наяд төгрөгөөр буурсан байна. **Бараа, үйлчилгээний импорт** 14.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.4 (18.7%) их наяд төгрөгөөр буурлаа.

Барааны экспортын бууралтад чулуун нүүрсний экспорт 2.2 (36.5%) их наяд төгрөг, боловсруулаагүй газрын тосных 492.9 (68.5%) тэрбум төгрөг, зэсийн баяжмалынх 452.4 (13.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Үйлчилгээний экспортын бууралтад аяллын үйлчилгээний экспорт 1.0 (93.9%) их наяд төгрөг, бизнесийн бусад үйлчилгээний экспорт 119.8 (28.4%) тэрбум төгрөг, албан томилолтын үйлчилгээний экспорт 94.1 (92.2%) тэрбум төгрөг, компьютер, мэдээллийн үйлчилгээний экспорт 35.4 (60.2%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Барааны импортын бууралтад автобензен 532.4 (24.0%) тэрбум төгрөг, суудлын автомашины импорт 314.6 (35.8%) тэрбум төгрөг, ачааны автомашины импорт 254.4 (31.0%) тэрбум төгрөг, бульдозер, авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, экскаваторын импорт 169.4 (38.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Үйлчилгээний импортын бууралтад тээврийн үйлчилгээний импорт 754.3 (38.1%) тэрбум төгрөг, бизнесийн бусад үйлчилгээний импорт 746.9 (48.2%) тэрбум төгрөг, аяллын үйлчилгээний импорт 541.4 (30.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2020 оны эхний 9 сард 12.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 976.1 (7.1%) тэрбум төгрөгөөр буурлаа (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

Бүрэлдэхүүн	2017 I-IX	2018 I-IX	2019 ¹ I-IX	2020* I-IX	$\frac{2019^1 \text{ I-IX}}{2018 \text{ I-IX}}$	$\frac{2020^* \text{ I-IX}}{2019^1 \text{ I-IX}}$
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	12 027.4	12 744.1	13 698.7	12 722.5	107.5	92.9
Эцсийн хэрэглээ	8 691.9	9 622.4	10 576.8	11 325.2	109.9	107.1
Өрхийн аж ахуй, ӨУАББ-ын эцсийн хэрэглээний зардал ^А	7 084.8	7 964.7	8 724.0	9 255.3	109.5	106.1
Төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардал	1 607.1	1 657.7	1 852.8	2 069.9	111.8	111.7
Хөрөнгийн нийт хуримтлал	3 637.9	4 551.2	5 815.5	3 859.5	127.8	66.4
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	2 763.7	3 675.3	4 727.3	4 543.8	128.6	96.1
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ^Б	874.2	875.9	1 088.2	- 684.3	124.2	-
Бараа, үйлчилгээний цэвэр экспорт	- 302.4	- 1 429.5	- 2 693.6	- 2 462.1	-	-
Бараа, үйлчилгээний экспорт	9 608.4	11 646.4	13 410.4	12 352.1	115.1	92.1
Бараа, үйлчилгээний импорт (-)	9 910.9	13 075.9	16 104.0	14 814.1	123.2	92.0

Тайлбар: ^А - Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

^Б - Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлалыг оруулсан.

Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ 2019 оны эхний 9 сард 7.5 хувиар өсөж байсан бол 2020 оны эхний 9 сард 7.1 хувиар буурлаа.


ДНБ-ий 2019 оны эхний 9 сарын 7.5 хувийн өсөлтөд хөрөнгийн нийт хуримтлал 9.9 пунктийн эерэг нөлөө үзүүлж байсан бол 2020 оны эхний 9 сарын 7.1 хувийн бууралтад хөрөнгийн нийт хуримтлал 14.3 пунктийн сөрөг нөлөө үзүүлсэн байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. ДНБ-ий бодит өсөлт, бууралтад бүрэлдэхүүн хэсгийн оролцоо, пунктээр

	2018*				2019*				2020*		
	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX
ДНБ-ий өсөлт, %	8.4	6.3	6.0	7.0	8.8	8.6	7.5	5.0	-10.9	-9.7	-7.1
Эцсийн хэрэглээ	15.1	10.4	7.7	7.1	7.2	7.1	7.5	7.6	5.2	5.0	5.5
Өрхийн хэрэглээ ³	14.2	9.8	7.3	7.0	5.8	5.3	6.0	5.8	4.2	3.8	3.9
Төрийн байгууллагын хэрэглээ	0.9	0.5	0.4	0.1	1.5	1.8	1.5	1.7	1.0	1.2	1.6
Хөрөнгийн нийт хуримтлал	6.1	7.6	7.6	6.1	8.0	8.7	9.9	11.1	-1.6	-8.7	-14.3
Үндсэн хөрөнгийн хуримтлал	9.3	8.6	7.6	5.5	11.6	7.8	8.3	6.9	-1.1	-2.3	-1.3
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ⁴	-3.3	-1.1	0.0	0.6	-3.5	0.9	1.7	4.2	-0.5	-6.3	-12.9
Бараа, үйлчилгээний цэвэр экспорт	-12.8	-11.7	-9.4	-6.2	-6.4	-7.2	-9.9	-13.7	-14.5	-6.1	1.7
Бараа, үйлчилгээний экспорт	24.4	17.9	16.9	18.6	9.3	13.2	13.8	8.2	-37.2	-17.5	-7.7
Бараа, үйлчилгээний импорт (-)	37.2	29.5	26.3	24.7	15.7	20.4	23.8	21.8	-22.8	-11.4	-9.4


Бараа, үйлчилгээний экспорт 2020 оны эхний 9 сард 14.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар буурсан. Экспортын топ-5 бүтээгдэхүүнд уул уурхайн бүтээгдэхүүн болох чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, алт (боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт), ноос, ноолуур багтаж байна. Өмнөх оны мөн үеэс алт 2.7 дахин, төмрийн хүдэр 2.0 хувиар өсөж, харин чулуун нүүрс 30.8 хувиар, ноос, ноолуур 7.3 хувиар, зэсийн баяжмал 0.1 хувиар тус тус буурсан байна (Зураг 16).

Зураг 16. Экспортын топ-5 бүтээгдэхүүн



Бараа, үйлчилгээний импорт 2020 оны эхний 9 сард 14.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар буурсан. Импортын топ-5 бүтээгдэхүүнд автобензин, ачааны машин, суудлын автомашин, бульдозер, авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, экскаватор, түүнчлэн цахилгаан эрчим хүч багтаж байна. Өмнөх оны мөн үеэс суудлын автомашин 26.3 хувиар, бульдозер, авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, экскаватор 14.9 хувиар, ачааны автомашин 11.4 хувиар, автобензин 3.3 хувиар, цахилгаан эрчим хүч 2.8 хувиар тус тус буурчээ (Зураг 17).

Зураг 17. Импортын топ-5 бүтээгдэхүүн



Хүснэгт 9. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2020* I-IX	2019* I-IX 2018 I-IX	2020* I-IX 2019 I-IX	
	тэрбум төгрөг				хувь		
Дотоодын нийт бүтээгдэхүүн							
ДНБ, оны үнээр	20 370.4	23 881.7	27 399.7	26 446.2	114.7	96.5	▲▼
ДНБ, 2010 оны үнээр	12 062.5	12 849.9	13 735.9	12 735.6	106.9	92.7	▲▼
ДНБ-ий бодит өсөлт, бууралт, %	6.0	6.5	6.9	- 7.3			
Уул уурхайн	- 0.7	1.5	7.0	- 20.7			▲▼
Уул уурхайн бус	8.0	7.9	6.9	- 3.7			▲▼
ХҮИ, өмнөх оны мөн үеэс, %	5.8	5.7	9.0	1.7			▲▲
Санхүүгийн сектор							
Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж	5 035.1	6 516.7	7 749.0	6 701.4	118.9	86.5	▲▼
Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээл	5 773.0	6 275.0	7 264.4	9 440.7	115.8	130.0	▲▲
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	- 737.9	241.7	484.6	-2 739.3	200.5	-	▲▼
Мөнгөний сектор							
Мөнгө М1, сарын эцэст	2 800.4	3 423.1	3 804.3	3 550.1	111.1	93.3	▲▼
Мөнгө М2, сарын эцэст	14 749.7	17 920.2	20 432.9	22 330.2	114.0	109.3	▲▲
Зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст	13 421.4	16 342.4	18 151.1	17 348.5	111.1	95.6	▲▼
Хадгаламж, сарын эцэст	10 029.3	12 222.7	13 705.8	16 670.2	112.1	121.6	▲▲
Гадаад сектор, сая америк доллар							
Нийт эргэлт	7 707.6	9 633.8	10 544.9	9 075.2	109.5	86.1	▲▼
Экспорт	4 582.9	5 282.8	5 946.1	5 147.0	112.6	86.6	▲▼
Импорт	3 124.7	4 351.1	4 598.8	3 928.1	105.7	85.4	▲▼
Тэнцэл	1 458.2	931.7	1 347.3	1 218.9	144.6	90.5	▲▼
Бодит сектор							
АҮ-ийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл	9 507.7	11 350.1	13 386.0	11 081.5	117.9	82.8	▲▼
Уул уурхай	6 895.5	8 121.3	9 694.4	7 607.8	119.4	78.5	▲▼
Уул уурхайн бус	2 612.1	3 228.8	3 691.6	3 473.7	114.3	94.1	▲▼
Барилга угсралт, их засварын ажил	3 001.5	3 458.6	3 826.7	3 773.4	110.6	98.6	▲▼
Дотоод худалдааны борлуулалт	10 293.3	14 363.4	16 904.7	15 243.2	117.7	90.2	▲▼
Шуудан, холбооны орлого	610.4	808.2	936.3	995.5	115.8	106.3	▲▲
Тээврийн нийт орлого	1 082.9	1 319.1	1 506.3	1 046.7	114.2	69.5	▲▼
Шилжүүлсэн сая тонн км	15 862.9	18 047.1	19 750.5	18 439.7	109.4	93.4	▲▼
Авто тээвэр	5 107.2	5 893.4	5 960.6	3 595.0	101.1	60.3	▲▼
Төмөр замын тээвэр	10 572.4	11 949.3	13 556.5	14 782.4	113.5	109.0	▲▲
Агаарын тээвэр	182.8	204.1	233.1	62.3	114.2	26.7	▲▼
Тээсэн ачаа, мянган тонн	40 077.9	48 746.8	50 847.4	39 948.0	104.3	78.6	▲▼
Авто тээвэр	23 816.5	30 021.6	30 367.5	17 816.9	101.2	58.7	▲▼
Төмөр замын тээвэр	16 257.5	18 721.0	20 475.5	22 129.2	109.4	108.1	▲▲
Агаарын тээвэр	3.9	4.2	4.3	1.9	101.6	45.2	▲▼
Зочид буудлын салбарын нийт орлого	119.4	166.0	207.6	101.7	125.0	49.0	▲▼
Нийтийн хоолны салбарын нийт орлого	240.8	295.5	357.6	328.7	121.0	91.9	▲▼
Нүүрс:							
Олборлолт, мянган тонн	36 176.5	33 764.8	38 583.7	22 884.8	114.3	59.3	▲▼
Экспорт, мянган тонн	25 773.4	27 380.3	28 743.8	19 868.0	105.0	69.1	▲▼

▲ өмнөх оны мөн үеэс өссөн
▼ өмнөх оны мөн үеэс буурсан